



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД БОЛОН
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН
2022 ОНЫ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

2022 он

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД БОЛОН
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН
2022 ОНЫ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2022.11.25

Дундговь

Д/д	Үндэслэж буй бодлогын баримт бичиг	Санхүү жилтий н эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин
0	1	2	3	4	5	6
Зорилт 1. Салбарын үйл ажиллагаанд дэмжлэгийг үзүүлэх						
1	Улсын төсвийн хөрөнгөөр тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа Улсын геологийн 1:200000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн Их хараат уул -50, Үнэгт уул -50, Улсын геологийн 1:20000-ны масштабын иж бүрдэл зургийг L хавтгайн хэмжээнд нэгтгэх УГЗ-200-нэгтгэл-L, геологийн сэдэвчилсэн судалгааны Мезо-Кайнозой-2021, Гүний хагарал – 1, 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх геологийн сэдэвчилсэн судалгааны Геологийн орчин -2022, Монгол орны хэмжээнд хийгдэх Мета-алт -500, өндөр технологийн түүхий эдийн ӨТТЭ-2-2022 төслүүдийн гүйцэтгэгч хуулийн хуулийн этгээдийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжих;	УТ	Дэмжиж ажилласан төслийн тоо	0	2	Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн тогтцыг судлах, ашигт малтмалын хэтийн төлөвийг тодорхойлох зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны “ Их хараат уул -50” төслийг тус аймгийн Адаацаг, Эрдэнэдалай сумын нутагт “Их хараат уул” талбайд “Гео-Мин” ХХК, Үнэгт уул –50 төслийг “Үнэгт уул” талбайд “Монгол Алт” ХХК тус бүр зураглалын ажлаа хийж гүйцэтгэсэн. Уг ажлыг гүйцэтгэхэд холбогдох сумаас Засаг даргын Тамгын газраас төслийн ажилтай холбоотой мэдээлэл хүргэж үйл ажиллагааг саадгүй явуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Бусад Улсын хэмжээнд хэрэгжиж буй Улсын геологийн 1:20000-ны масштабын иж бүрдэл зургийг L хавтгайн хэмжээнд нэгтгэх УГЗ-200-нэгтгэл-L, геологийн сэдэвчилсэн судалгааны Мезо-Кайнозой-2021, Гүний хагарал – 1, 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх геологийн сэдэвчилсэн судалгааны Геологийн орчин -2022, Монгол орны хэмжээнд хийгдэх Мета-алт -500, өндөр технологийн түүхий эдийн ӨТТЭ-2-2022 төслүүд нь Дундговь аймагт хэрэгжээгүй байна. Хэрэгжилт 100 хувь
2	Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны бүтээгдэхүүн	-	Дэмжиж ажилласан аж ахуйн нэгжийн тоо	0	1	Сайхан-Овоо сумын нутагт орших Төгрөг хайрхан уулын орчимд Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий Нүүрсний давхрагын метан хийн хайгуулын үйл ажиллагаа явуулж буй “Петровис ресурс”ХХК-ны үйл

	хуваах гэрээт талбай эзэмшигчийн үйл ажиллагааг орон нутгийн зүгээс дэмжих;					ажиллагаанд хяналт шалгалт хийх орон нутгийн малчид иргэдтэй уулзалт зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэн тус талбайд аймгийн ЗДТГ, МХГ, Цагдаагийн газар, БОАЖГ зэрэг холбогдох байгууллага албан хаагчид удаа дараа ажиллаж гарсан зөрчлийг арилгах албан шаардлага болон торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Хэрэгжилт 100 хувь
3	Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэрээний загвар”-ын дагуу уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, компанитай байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг жил бүр дүгнэх;	-	Хамтран ажиллах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоогоор	6	26	2022 онд Аймгийн Засаг даргатай уул уурхайн нийт 26 ААН, 1,255.0 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээ байгуулснаас гэрээний дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд 11 аж ахуйн нэгжээс 309.5 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Гэрээний биелэлтийг дүгнэх Хамтын ажиллагааны хороог байгуулан 2023 оны нэгдүгээр улиралд багтаан дүгнэх уулзалт арга хэмжээг зохион байгуулж олон нийтэд танилцуулна. Хэрэгжилт 100 хувь
4	Тухайн аймгийн нутаг дэвсгэрт олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж өөрийн хайгуулын талбайд хайгуулын ажил хийхэд дэмжлэг үзүүлж ажиллах;		Дэмжиж ажилласан аж ахуйн нэгжийн тоо	-	2	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн 30 аж ахуй нэгжийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хүлээн авсан байна. Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдан хайгуулын ажлын явцад орон нутгийн малчид, иргэдийн эсэргүүцэл үүссэн Өлзийт сумын нутагт орших “Хайрхан” нэртэй талбайд “Гурвансайхан”ХХК-ны ураны хайгуул, Дэрэн сумын Долоод багийн нутагт сумын төвөөс зүүн хойш 30 км-т “Майхан гуя” гэх газарт “Хэрсэн” нэртэй хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Генерго”ХХК-ны хайгуулын ажил, Сайхан-Овоо сумын нутагт орших Төгрөг хайрхан уулын орчимд Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий Нүүрсний давхаргын метан хийн

						хайгуулын үйл ажиллагаа явуулж буй “Петровис ресурс” ХХК-ны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх орон нутгийн малчид иргэдтэй уулзалт зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэн сумдад удаа дараа ажиллаж гарсан зөрчлийг арилгах албан шаардлага болон торгуулийн арга хэмжээ авч нийт 3 аж ахуй нэгжийн талбайд ажилласан байна. Хэрэгжилт 100 хувь
5	Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас хүлээн авсан мөнгөн болон мөнгөн бус хандивыг нийтэд мэдээлэх ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах;	-	Тайланг нийтэд мэдээлж, ОУИТБС-ын албанд хүргүүлсэн байх	1	1	Аймгийн нутаг дэвсгэрт 2021 онд уул уурхай ашигт малтмалын олборлолт, боловсруулах үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан аж ахуй нэгжээс орон нутгийн төсөвт нийт 1.6 тэрбум төгрөгийн татвар, хураамж, төлбөр төсөвт төвлөрч, 10 аж ахуйн нэгжээс 56.8 сая төгрөгийн хандив тусламжийг орон нутагт үзүүлсэн байна. Энэхүү тайланг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын албанд хүргүүлсэн. Тайлант оны мэдээ ирэх оны эхний улиралдаа багтаж гардаг учир одоогоор тайлан гарах хугацаа болоогүй байна. Хэрэгжилт 70 хувь
6	Үйлдвэрийн зориулалттай тэсрэх материалын үйлдвэр, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахыг батлагдсан зураг төслийн дагуу бариулж, стандарт, шаардлагыг хангуулах, аянга зайлуулагчийн эсэргүүцлийг тогтмол хэмжүүлэх зэрэг ажлыг орон нутагт зохион байгуулах, тогтоогдсон аюулгүйн бүсэд газар олгохгүй байх;		Хяналт, шалгалтад хамрагдсан тэсэлгээний агуулахын тоо	5	8	Аймгийн хэмжээнд уул уурхайн 8 баяжуулах үйлдвэр байдаг бөгөөд “Эрдэнэс силвер ресурс” ХХК, “Шанжин Орд” ХХК, “Болор жонш” ХХК, “Минг Ханда” ХХК, “Эм Ди Эф И” ХХК, “Тайшен девелопминт” ХХК, “Чинхаш” ХХК, “Говь шоо” ХХК, “Эрдгео” ХХК зэрэг аж ахуй нэгжүүд ашиглалтын талбайдаа үйлдвэрийн зориулалттай тэсэлгээний хэрэгслийн агуулахтай. Энэ онд уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 9 аж ахуй нэгжүүдэд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил байхгүй. Урьд онуудад тэсэлгээний хэрэгслийн агуулахын байршлаа тогтоолгосон аж ахуйн нэгжүүдэд тогтоогдсон аюулгүйн бүсэд газар олгохгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгч ажилласнаар тэсэлгээний агуулахын тогтоогдсон аюулгүйн бүсэд газар олгогдоогүй. Хэрэгжилт 100 хувь

7	Яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бусад асуудлаар орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах;	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 16 аж ахуйн нэгж байгууллагад хайгуулын өрөмдлөг, зам талбайн тоосжилт дарах, унд ахуйн зориулалтаар ус ашиглуулах дүгнэлт гаргаж холбогдох сумд ус ашиглах гэрээ байгуулан ажилласан байна. Ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулдаг 2 аж ахуйн нэгжид уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх маршрутыг баталсан. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 9 өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн 6 аж ахуйн нэгжид түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл, 16 аж ахуйн нэгжийн түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд 2 жилээр сунгалт хийж, 2 талбайг цуцлах шийдвэр гарган ажилласан байна. Хэрэгжилт 100 хувь
8	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажил, ашигт малтмал, газрын тосны уламжлалт болон уламжлалт бус эх үүсвэрийн эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагааг хууль бусаар зогсоох, саад учруулахгүй байх талаар сум, орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, иргэдэд танилцуулах, саад учруулах үйлдэл гаргасан тохиолдолд хуулийн хариуцлага тооцох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хуульд заасны дагуу хяналт тавьж ажиллах;	-	Үйл ажиллагааны тоо	-	2	Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдан хайгуулын ажлын явцад орон нутгийн малчид, иргэдийн эсэргүүцэл үүссэн Өлзийт сумын нутагт орших “Хайрхан” нэртэй талбайд “Гурвансайхан”ХХК-ны ураны хайгуул хийх ажилтай холбогдуулан тус газрын Буянт 2 дугаар багийн ИНХурал, Өлзийт сумын ИТХ-ын хурлын шийдвэрийг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж ажилласан. Сайхан-Овоо сумын нутагт орших Төгрөг хайрхан уулын орчимд Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын үйл ажиллагаа явуулж буй “Петровис ресурс”ХХК-ны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх орон нутгийн малчид иргэдтэй уулзалт зохион байгуулах, тус сумын ИТХурал үүссэн нөхцөл байдлаас болж хуралдсан ээлжит бус хуралдааны тогтоолыг аймгийн ИТХ-д 2 аж ахуй нэгжийн үйл ажиллагааг танилцуулсан. Хэрэгжилт 100 хувь

9	Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулж шинжлэх ухааны үндэслэлтэй гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын үр дүнд тогтоосон ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайг сонгон шалгаруулалтын талбайгаар зарлахтай холбоотойгоор саналаа хууль, тогтоомжийн хүрээнд хугацаанд нь өгөх;		Ирсэн саналын тоо	-	-	2022 онд хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох талбайн солбицолд санал авах албан бичиг, тоот ирээгүй. Тайлант онд шинээр ашиглалтын тусгай зөвшөөрөл 2, хайгуулын тусгай зөвшөөрөл 1 аж ахуй нэгжид олгогдсон байна. Хэрэгжилт 100 хувь
10	Орон нутагт ашигт малтмалыг хууль бусаар олборлохыг таслан зогсоох ажлыг санаачлан зохион байгуулах;	-	Зохион байгуулсан хяналт шалгалтын тоо	2	5	Бичил уул уурхай болон дэд бүтцийн улмаас эвдэрч орхигдсон газрын тооллогыг “Эко Ти Эс Би” ХХК-тай гэрээ байгуулж 6 сумын 13 нэгж талбар бүхий газарт, Гурвансайхан сумын Засаг дарга мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан тус сумын 5 нэгж талбар бүхий газарт, нийт 7 сумын 18 нэгж талбар бүхий газарт тооллогын ажлыг зохион байгуулсан. Тооллогын дүнгээр нийт хууль бус ашигт малтмал олборлолтын улмаас эзэнгүй эвдэрч орхигдсон 91.4 га талбай бүртгэгдсэн. 2018 оны тооллогын дүнтэй харьцуулахад 54.4 га талбай нөхөн сэргээгдэж буурсан үзүүлэлтэй байна. БХНСАХЗардлаас 10.0 сая төгрөг зарцуулав. Энэ онд 8 удаагийн хяналт шалгалтаар тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны явцад эвдрэлд орж нөхөн сэргээлт хийгдэлгүй хаягдсан 2 байршил бүхий талбайд учруулсан хохирлыг барагдуулах ажлыг экологийн цагдаагийн алба мэргэжлийн байгууллагаар хохирлын үнэлгээ тооцуулан хэрэг бүртгэлийн хэрэг үүсгэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Хэрэгжилт 100 хувь
11	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах явцад бусад төрлийн ашигт малтмал ашиглахгүй байх талаар зохих	-	Хяналтын шалгалтын тоо	1	5	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудад аймгийн ЗДТГ, мэргэжлийн хяналтын газар, цагдаагийн газар болон МХЕГ, Экологийн цагдаагийн албанаас нийт 8 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулахад түгээмэл тархацтай

	арга хэмжээ авах, түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч, холбогдох газар мэдээлэх;					ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны явцад эвдрэлд орж нөхөн сэргээлт хийгээгүй орхисон 2 байршил бүхий талбайд учруулсан хохирлыг барагдуулах ажлыг мэргэжлийн байгууллагаар хохирлын үнэлгээ тооцуулан хэрэг бүртгэлийн хэрэг үүсгэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Хэрэгжилт 100 хувь
12	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дэмжих	-	Арга хэмжээний тоо	2	9	Ашигт малтмал, Газрын тосны газрын тусгай зөвшөөрлийн улирал бүрийн хөдөлгөөний мэдээнд үндэслэн нэмэлт өөрчлөлт оруулж баяжилт хийн холбогдох сумд, байгууллагуудыг мэдээллээр ханган ажилласан. Аймгийн нутаг дэвсгэрт 2021 онд уул уурхай ашигт малтмалын олборлолт, боловсруулах үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан аж ахуй нэгжээс орон нутгийн төсөвт нийт 1.6 тэрбум төгрөгийн татвар, хураамж, төлбөр төсөвт төвлөрч, 10 аж ахуйн нэгжээс 56.8 сая төгрөгийн хандив тусламжийг орон нутагт үзүүлсэн байна. Энэхүү тайланг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын албанд хүргүүлсэн. 2022 оны мэдээг ирэх 1 дүгээр сард ОУИТБС-ын албанд хүргүүлнэ. Сумдын дэд зөвлөлийг тайлан гаргахтай холбоотой заавар зөвлөмжөөр хангаж ажилласан. Мөн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын албанаас зохион байгуулсан цахим сургалтад 3 удаа, дэд зөвлөлийн 3 гишүүн, танхимын сургалтад 2 гишүүн тус тус хамрагдсан. Хэрэгжилт 100 хувь
13	“Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ыг хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах	-	Хамтран ажилласан төслийн тоо	1	1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК, Дундговь аймаг, Канадын ЗГ-ын санхүүжилттэй MERIT төсөл хамтран хэрэгжүүлэх Салхитын уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах жишиг төслийн талаар олон удаагийн цахим сургалт хурал, иргэдэд мэдээлэл өгөх нээлттэй хаалганы өдөрлөг” хоёр өдрийн арга хэмжээг “Мэрит” төсөл “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК, Гурвансайхан сумын

						ЗДТГ-тай хамтран тус сумын төвд 2022 оны 9 сарын 28,29 өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус өдөрлөгт Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон өөрсдийн үйл ажиллагааг сурталчлах болон иргэдэд нэг цэгийн үйлчилгээг, Хөдөө аж ахуйн газраас бичил үйлдвэрлэл үйлчилгээ үзүүлэгч явуулын ахуй үйлчилгээг иргэдэд хүргэж хамтран ажиллаж 300 орчим иргэдэд уурхайн хаалт болон бусад мэдээлэл үйлчилгээг хүргэсэн. Нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, эвдэрсэн газрыг бууруулах зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 17.77 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 18.54 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдэж, нийт 36.31 га талбайд нөхөн сэргээлт хийгдлээ. Хэрэгжилт 100 хувь
14	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн мод тарих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах. Тухайн бүс нутгийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан тарих модны тоо, газрын байршил, хэмжээг тогтоох чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хамтран ажиллаж, хяналт тавих.	Хуви йн хэвш лийн хөрө нгө оруул алт	Байгаль орчны менежменти йн төлөвлөгөөн д тусгасан модны тоо	-	10000	2022 онд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулах 12 ААНэгжийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тусгуулсан. Үүнээс 8 ААНэгж 72600 мод, 2 ААНэгж 11 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 1 аж ахуйн нэгж уст цэгийн тохижилт, цөөрмийн ажлыг тус тус хийж гүйцэтгэв. Хэрэгжилт 100 хувь
15	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн Дэд зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор түүний үйл ажиллагаанд	ОНТ буса д эх үүсвэ р	Зохион байгуулсан үйл ажиллагаан ы тоо	1	3	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УУХҮЯам, АМГТГазар, Дундговь аймгийн ЗДТГазар хамтран “Ашигт малтмал, уул уурхайн салбарын зөвлөлдөх

	дэмжлэг үзүүлж, холбогдох зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж ажиллах.					уулзалт-2022” арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Монгол Улсын "ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА"-ыг орон нутагт хэрэгжүүлэх Дэд зөвлөлүүдийн сургалтад аймгийн дэд зөвлөлийн 2 гишүүн хамрагдсан. Канад улсын MERIT төсөл, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газартай хамтран “Уул уурхайн худалдан авалтад жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг холбох арга зүй” гарын авлагыг боловсруулан, төсөл хэрэгждэг Дундговь аймгийн Жижиг, дунд, үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтнүүд, сумдын мэргэжилтнүүдэд гарын авлагын танилцуулга сургалтыг зохион байгуулав. Энэ үеэр тус аймгийн “Уул уурхайн бэлтгэн нийлүүлэлтийг дэмжих ажлын хэсэг”-ийн уулзалтуудыг зохион байгуулж, цаашид уул уурхайн худалдан авалтад орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг холбох ажлыг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж 15 сумдын ЖДҮ хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, нийт 26 аж ахуй нэгжид Дундговь аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэдийн 70 сая төгрөгийн бараа нийлүүлэлтийг хийгээд байна. Нээлттэй хаалганы өдөрлөг, хамтран ажиллах гэрээний болон ЖДҮ-ийн сургалт тус тус 2 удаа цахим, 2 удаа танхим нийт 9 удаагийн арга хэмжээ зохиогдсон байна. Хэрэгжилт 100 хувь
16	Салбарт мөрдөгдөж буй төрийн бодлого, хууль тогтоомжийг орон нутагт сурталчлан таниулах, хэрэгжүүлэх ажлыг холбогдох яам, агентлагтай хамтран зохион байгуулах;	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	УУХҮЯам, АМГТГазар, Дундговь аймгийн ЗДТГазар хамтран “Ашигт малтмал, уул уурхайн салбарын зөвлөлдөх уулзалт-2022” арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. ХХҮГазар, МСҮТөвтэй хамтран уул уурхайд ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэж мэргэшүүлэн ажилд зуучлах ажлыг 4 дүгээр сард

						<p>зохион байгуулсан. Салхитын мөнгөний ордод одоогийн байдлаар байдлаар 53 хүн орон нутгаас ажиллаж байна. Мөн 15 сумын хэмжээнд түр болон бүр ажлын байраар иргэд хамрагдаж байна. Мөн 7,8,9 саруудад БОАЖЯ, АМГТГ, МХЕГ, Цөмийн энергийн газрын ажлын алба, Экологийн цагдаагийн албатай хамтран Өлзийт суманд, 11 сард БОАЖЯ, АМГТГ, Усны газартай хамтран Сайхан-Овоо суманд тус тус салбарт мөрдөгдөж буй төрийн бодлого, хууль тогтоомжийг орон нутагт сурталчлан таниулах, хэрэгжүүлэх ажлыг нийт 6 удаа зохион байгуулсан.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>
17	<p>Засаг даргын тамгын газрын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэнг салбарын шинэ мэдээллээр хангах, холбогдох сургалтад хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;</p>	-	<p>Хамрагдсан, сургалт, семинарын тоо</p>	2	3	<p>Засаг даргын тамгын газрын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн нь 2022 оны 8 дугаар сард ажилд томилогдсон бөгөөд БОАЖЯ, УУХҮЯ, АМГТГ-ын холбогдох мэргэжилтнүүдээс утсаар мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажиллаж байна. 8 дугаар сарын 25-с 9 дүгээр сарын 28-ны хооронд Канад улсын техникийн зөвлөхүүдээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авахаар “Мерит” төсөл санал хүргүүлсний дагуу уул уурхайн мэргэжлийн зөвлөхүүд тус аймагт ажилласан бөгөөд энэ ажлын хүрээнд уул уурхай хариуцсан мэргэжилтэн болон гэрээ байгуулах ажлын хэсгийн гишүүдэд Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулдаг “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ”-г сайжруулах, уул уурхайн үйл ажиллагаанаас орон нутгийн иргэдийн хүртэх үр шимийг нэмэгдүүлэх, улмаар орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, “Уул уурхайн худалдан авалтад жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг холбох арга зүй” зэрэг сэдвүүдээр зөвлөх үйлчилгээ үзүүлэв. Мөн бөгөөд 11 дүгээр сард Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын албанаас зохион байгуулсан 3 удаагийн цахим сургалтад аймгийн Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын</p>

						бодлогын мэргэжилтэн тус тус хамрагдсан. 2022 онд цахим болон танхимын сургалтад нийт 6 удаа хамрагдсан байна. Хэрэгжилт 100 хувь
18	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийг сурталчлан хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах, журмыг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллах;	-	Журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	1	Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/279 дугаар тушаалаар “Бичил уурхайн зохицуулалтын талаар” ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэн боловсруулж улмаар “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 296 дугаар тогтоол гарсантай холбогдуулан бүх сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, нарийн бичиг, ЗДТГ-ын дарга нарын бүрэлдэхүүнд 296 дугаар журмын танилцуулгыг бэлтгэн албан бичгээр 1 удаа чиглэл хүргүүлж, танхимын сургалтаар 1 удаа мэдээлэл хүргэсэн зэрэг нийт 2 удаа, журамтай холбогдуулан утсаар асууж буй сумдад мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна. Мөн бичил уурхайн мэргэжлийн холбоо болон нийт бичил уурхай эрхлэгчдийн судалгааг гаргав. Шинэ журмын дагуу одоогоор 2 талбайд дүгнэлт гаргуулахаар АМГТГазарт саналаа хүргүүлээд байна. Хэрэгжилт 100 хувь
19	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан гэрээ бүрийг www.iltodgeree.mn эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд байршуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;	-	Ил тод мэдээлсэн гэрээний тоо	6	10	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 26 аж ахуй нэгжтэй хамтран ажиллах гурвалсан гэрээ, хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсан хэдий ч www.iltodgeree.mn сайтад 2022 онд гэрээ байршуулаагүй байна. Хэрэгжилт 0 хувь
20	Түгээмэл тархацтай ашигт малтмал, барилгын материалын ашиглалт, олборлолтын мэдээ, нөөцийн	-	Төлөвлөгөө хянуулсан аж ахуй	2	5	Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын 2, хайгуулын 56 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаагаас ашиглалтын 2

	хөдөлгөөний мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газрын чиглэл хариуцсан нэгжид улирал бүр ирүүлэх;		нэгжийн тоо, ОНТөсөвт орлого төвлөрүүлэх			талбайн уулын ажлын төлөвлөгөө, хайгуулын 6 талбайн төлөвлөгөөг хянан баталсан. Орон нутгийн бүтээн байгуулалтад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын төрлийн бүтээгдэхүүнээр ханган ажиллаж орон нутгийн төсөвт 2022 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 13.343.700 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Хэрэгжилт 100 хувь
21	е/ Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлж байгаа орлого тухайн сум орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөллөө үзүүлж, үр ашгаа үзүүлж байгаа талаар болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж байгаа аж ахуй нэгжүүдийг сурталчлах, тухайн жилийн эцэст дээрх орлогын үр өгөөжийн талаар тайланг ирүүлэх;	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	100	2022 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн нийт 7.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийн 1.7 тэрбум төгрөг нь ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс төвлөрүүлсэн орлогоос санхүүжигдсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, түүний зарцуулалт, үр өгөөж, зарцуулалтын талаарх мэдээллийг аймгийн цахим хуудсаар тогтмол иргэдэд нээлттэйгээр хүргэж байна. Хэрэгжилт 100 хувь
Хэрэгжилт 93.8						

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:
ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

ТАЙЛАН ХЯНАСАН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ЭРДЭНЭ-ОЧИР

ТАЙЛАН БИЧСЭН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНЧИМЭГ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ОДОНЧИМЭГ